

Доктор, профессор Д. Дагвадорж
ШУТИС-ийн Хүмүүнлэгийн Ухааны
Сургуулийн тэргүүлэх профессор

БУДДЫН ГҮН УХААНЫ ОРЧИН ҮЕИЙН ҮНЭЛЭМЖИЙН АСУУДАЛД

Түлхүүр үг: Үнэлэмж, үнэлэмжлэхүй, шинэтгэл, мэдэгдэхүүний орон, арга билгийн зохицол, шашинжихуй, иргэншихүй, амьд хүрээ.

Товч утга: Орчин үеийн шашин судлалд буддын шашин-гүн ухааны нийгмийн оюуны амьдралд гүйцэтгэж буй үүргийг үнэлэмжлэх асуудал тодорхой байр суурьтай болж байна. Үүнтэй холбогдуулан буддын гүн ухааны орчин үеийн үнэлэмжийн асуудлыг мэргэдийн судалгаанд тулгуурлан, түүнийг буддизмын өөрийн шинэчлэлт хийгээд орчин үеийн сэтгэлгээнд эзлэх байр суурь, нийгмийн амьдралд гүйцэтгэж буй эерэг сөрөг хандлагатай холбон үзэж үнэлэмжлэх талаар энд тойм төдий илэрхийлэх ородлогыг хийв.

1987 онд Шинэ Зеландын Махамудра төвийн тэргүүн Зопа ринбүүчи, түвдийн нямава ёсны их ламтан Жамъяндагва нар *“Буддын оюун судлахуйн үндэс”* хэмээх бүтээлдээ *“Бид буддын ёсны эх сурвалжаа бодитой удирдлага болгохын хамт орчин үетэй зохицон уламжлуулах ёстой”* /1/ гэсэн санааг дэвшүүлсэн байдаг. Энд буддын сэтгэлгээ, түүний гүн ухааны сурвалжийг судлан боловсруулахад анхаарах ёстой 2 гол зүйлийг үнэлэмжилсэн нь харагддаг юм. Энэ нь нэгдүгээрт, Бурхан Буддагийн сургаал бол өөрийн үүсэл гарлаар танин мэдэхүй, гэгээрэхүйн сургаал учраас түүний үндсийг гуйвуулалгүй дотоод мөн чанарыг хадгалан хойч үедээ өвлөн уламжлуулах ёстой гэдгийг, хоёрдугаарт, Буддын сургаал, түүний гүн ухааны утга агуулга нь өөрөө хөрвөдөг номлол учраас зөвхөн нэгэн өнцгөөс харж догм богож болохгүй, тухайн үеийн сэтгэлгээний үнэ цэнээр баяжуулан хөгжүүлэх ёстой гэсэн санаа хэмээн үзэж байна.

Америкийн Вержинагийн их сургуулийн профессор Хоффкенис *“Бясалгал ба хоосон чанар”* бүтээлдээ *“Буддын гүн ухаан, орчин үеийн сэтгэлгээнд гүнзгий нэвтрэн өрнийнхнийг гэгээрүүлэхэд чухал түлхэц болж байна. Буддын гүн ухаанд буугдаж буй үйл явдал бүр учир шалтгаантай гэдэг зарчим гагцхүү бидний шүүн тунгааж болох хэмжээгээр үзвэл мэдрэхүйн ертөнцтэй холбож байгаа юм. Харин шинжлэн буй шалтгааныг үнэмлэхүй хэмжээнд рациональ байдлаар үзвэл түүнийг тайлах нэгэн*

түлхүүр болж чадах юм" /2/ гэсэн нь буддын гүн ухааны орчин үеийн ач холбогдлыг үнэлэмжилсэн хэрэг хэмээн үзэж буй бөгөөд энд танин мэдэхүйн асуудлыг үнэлэмжтэй холбон тавьсан хэрэг байв.

Доктор Хельмут Клар "Барууны буддистууд ихэнх нь өндөр боловсролтонгуудтай холбоотой бөгөөд тэр нь буддизмыг оюуны ертөнцийг өндөр түвшинд хүлээн авдаг гэсэн хэрэг. Дорнын шашин – суртахууны уламжлалыг рационалист хандлагатайгаар хүлээн авч үздэг хэмээн үзэх үндэстэй болохыг энэ нь харуулж байгаа юм" /3/ хэмээсэн бол академич Н. Кондрад "Буддын шашин гэдэг бол дан ганц шүтлэгийн номлол биш, энэ бол амьдрал ахуйн тухай өөрийн сургаалтай, танин мэдэхүйн өөрийн онолтой гүн ухаан юм, энэ бол ёс суртахууны сургаал юм, энэ бол нийгэм улс төрийн тухай сургаал юм. Эцэст нь энэ бол уран барилга, баримал, уран зургийн зэрэг цэцэглэн хөгжсөн буддын гайхамшигт урлагийн тугийн доорх гоо зүйн үзэл бодлын тогтолцоотой сургаал юм" /4/ хэмээжээ.

Энд л буддын сэтгэлгээ, гүн ухааны орчин үеийн үнэлэмжийн тухай асуудал хөндөгдөж буй нь тодорхой. Бидний үзэж байгаагаар энэхүү үнэлэмжүүдийг дараах 2 үндэслэлээр тодорхойлогдож болох байна хэмээн үзэж болохоор байгаа юм. Энэ нь:

1. Буддын гүн ухаан бол философи сэтгэлгээний бүрэлдэхүүнд хамаарах дорнын сэтгэлгээн дэх үзэл санааны цогц сургаал болохыг үнэлэмжилсэн явдал. Энд дорнын гэдэг нь газар зүйн утгаар бус, соёл иргэншлийн хувьд өрнөөс ялгаатай иргэншил бий болсон. Тэр нь дорнын нийтлэг шинжийн илэрхийлэл бөгөөд тухайн улс үндэстний буй болгосон сэтгэлгээний баялаг хуримтлал нь энэхүү онцлогт хамаарна хэмээсэн хэрэг юм. Харин энэхүү үнэлэмж философи сэтгэлгээнд оруулсан хувь нэмрээр хэмжигдэх нь зүйн хэрэг болой.

Буддын сэтгэхүй нь рациональ түвшинд бясалгалын эрдмийг багтаасан гүн нарийн философийн сургаал учраас "Өрнийнхнийг соён гэгээрүүлэхэд" оруулсан хувь нэмрээр хэмжигдэнэ хэмээн үзсэн нь буддын гүн ухааны орчин үеийн үнэлэмжийг харуулж байна хэмээн үзэхэд хүргэж байгаа юм.

2. Буддизм нь "шашин" хэмээхээр харьцангуй томъёологддог ч "мэдэгдэхүүний орон бүхнийг дотроо багтааж" байдгийн хувьд танин мэдэхүйн гүн ухааны цогц сургаал болж, түүнийг шинжлэх ухааны үүднээс нотлох нь үнэлэмжилэхүйн чухал хүчин зүйл болох ёстой гэж үзэх явдал мөн.

Учир юун хэмээвээс дорнын буддын шашин нь өөртөө дорно дахины эрдэм ухааны мэдлэгийн сангаар баяжигдан, дэлгэрсэн орныхоо соёлын хөрсөнд идээшлэн зохицож, эд өлгийн соёлын өв болж хөгжсөнтэй холбоотой юм. Тухайлбал монголын буддизм бол монгол угсаатны олон зуун жилийн төрт ёс, соёл иргэншил, зан заншлын арвин их өвийг агуулсан үнэт зүйл болж ирсний хувьд монголын соёл иргэншлийн шавхагдашгүй өв болж монголчуудын баримталдаг ёсонд түүний төв голч үзэл, арга билгийн зохицлын гүн ухаан эрхэмлэх үзэл санаа шингэн уусаж танин мэдэхүйн баялаг өв санг буй болгосонтой энэ нь холбоотой билээ.

Ийнхүү буддизм дорно дахины ч, өрнө дахины ч рационалист сэтгэлгээний баялаг өв сан болж ирсэн нь судлаачдын судалгааны объект болж, түүнийг орчин үеийн сэтгэлгээний үүднээс үнэлэмжилэхэд хүргэжээ. Буддын гүн ухааны орчин үеийн үнэлэмжийн талаар бас нэгэн баримтыг дурдъя.

XIV Далай лам Данзанжамц 2002 онд ШУТИС-ийн Хүмүүнлэгийн ухааны хүндэт докторын диплом хүлээн авахдаа "Буддизм өөрөө хүмүүнлэгийн ухааны үзэл санааны эрхэмлэл нь юм. Түүний үзэл санааг дэлгэрүүлэх нь миний үүрэг. Бид буддын энэрэнгүй ёсны үзлийг барууны соёлжсон орны оюуны хэрэгцээ болгон нэвтрүүлнэ. Би Түвд орноос цагаачлан гарсан ч буддын соёлыг түгээх талаар хожсон. Учир юун хэмээвээс Дармасалад бурхантны орчин үеийн сургалтын төв бий. Энэ сургуулийг төгссөн залуучуудыг барууны өндөр хөгжилтэй орнуудад илгээн орчин үеийн боловсролтой болгож байна. Тэнд тэд өндөр боловсролтой, тэгээд ч буддын соёлоор хүмүүжсэн учир буддын хүмүүнлэг үзлийг дэлгэрүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэх болсон" /5/ гэсэн буй.

Энд буддын соёлын орчин үеийн үнэлэмжийг түүний үзэл санааны гүн утга агуулгыг дэлгэрүүлэхтэй холбон тодорхойлсон хэрэг байв. Дээрх үндэслэлд тулгуурлан буддын шашин, гүн ухааны үнэлэмжийн асуудлыг буддизмын өөрийн шинэчлэгдсэн байдал, тэр нь орчин үеийн сэтгэлгээнд эзлэх байр суурьтай холбон үзэх нь зүйн хэрэг. Тэгэхдээ буддизм, түүнд боловсрогдсон үзэл санаа хийгээд буддын гүн ухааны уламжлалт сэтгэлгээнд хэрхэн хандаж, түүнийг шинжлэх ухааны үүднээс шинжилж, философи сэтгэлгээнд оруулсан хувь хэмжээгээр дүгнэн цэгнэх байдлаар илэрхийлэх нь зүйн хэрэг хэмээн үзэхэд хүргэж байгаа юм. Үүнийг дараах асуудлаар тодорхойлох оролдлогыг энд хийв. Үүнд:

Нэгдүгээрт, Буддизмын шинэтгэлийн асуудал үүнд зүй ёсоор хамаарна. XX зууны сүүлийн хагаст судлаачдын анхааралд шашны шинэтгэлийн асуудал тавигдах болов. Энэ нь шашинжихуй (сакрализиаци), иргэншихуй (секуляризиаци) хандлагаар илэрч буй бөгөөд ертөнцийг үзэх шашны үзлийг шинжлэх ухааны үзлээр халах, эсвэл тэрхүү үзлийг орчин үетэй холбон шашны үнэт чанар, хэм хэмжээг соёлжуулах хүчин зүйл болгон өргөмжлөх замаар үнэлэмжийн асуудлыг тавьж, тэр нь нийгмийн шинэчлэлийн үрээр хэмжигдэнэ хэмээн үзэхэд хүргэж байгаа юм. Энэ бол шашны нийгэмд гүйцэтгэх үүрэг (функц) түүхэн тодорхой нөхцөлд ямагт өөрчлөгдөж байдгийн зүй ёсны илэрхийлэл болно.

Бидний үдэн өнгөрүүлсэн XX зуун гэхэд нийгмийн амьдралын бүх хүрээ салбар үндсээрээ өөрчлөгдсөн хувьсгалт өөрчлөлтийн зуун болсон. Эдгээрийн үрээр сүсэг бишрэлийн суурь хөрс шинэ агуулгаар баяжигдан, шинжлэх ухаан технологийн үсрэнгүй хөгжил шийдвэрлэх үүргийг гүйцэтгэх болов. Үүний үрээр шашинд шинэ байдлаар хандах, хуучин догм сургаал, хэвшил болсон зан үйл, сүм хийдийн зохион байгуулалт, сүсэгтэнтэй харьцах харилцааг түүхэн шинэ нөхцөлд зохицуулан шинэтгэх нь хүмүүжил төлөвшилд гүн нөлөө үзүүлэх чухал үндэс болох ёстой юм. Энэ бол эцсийн дүнд шашны шинэчлэлтэй холбоотой бөгөөд ийм үйл явц буддын шашин-номын ёсонд ч ажиглагдсаар буйг судлаачид тэмдэглэсээр байгаа юм.

Миний ойлгож байгаагаар энэ нь шашны үндэс, сургаал илт хуучирсан, орчин үеийн нийгмийн ба иргэншлийн ололтоор баяжигдаагүйн улмаас түүнийг сурталчлахдаа орчин үетэй механикаар холбон тайлбарлахаас хэтрэхгүй байгаад оршиж байна. Чухам ийм учраас бурхны шашны шинэчлэлтийн тухай ярихдаа шашин номын үзэл санааг шинэлэг арга ухаанаар баяжуулах, орчин үеийн нийгмийн амьдралын утга учир, хүний оршихуй, аж төрөх ёстой гүн уялдуулан нийтлэг аргаар ухуулан, ухааруулах арга билгийг хослон гүйцэтгэх ёстой. Эдгээрийн үр дүн нь шашинд хандах үнэлэмжийн асуудал шинэлэг байр сууринаас тавигдахад хүргэнэ хэмээн үзэж байна.

Хоёрдугаарт, Буддын шашин-гүн ухааны судалгааг орчин үеийн сэтгэлгээнд буулган, эрдэм судлалын үүднээс дүгнэн боловсруулах явдал зүй ёсоор орно. Буддын сургаалын хөрвөдөг чадварыг онож тайлах, уламжлалыг шинэлэг хувилбараар боловсруулан орчин үеийн сэтгэлгээний үүднээс

судлан боловсруулах нь буддизмын нийгэмд эзлэх байр суурь, нийгмийн сэтгэлгээнд оруулж буй хувь хандлагыг үнэлэх шалгуурыг тогтоох үндсийг тавьж өгнө гэсэн хэрэг болой. Орчин үед энэхүү судалгаа давамгайлах талтай буйг буддын судлал дахь үйл ажиллагаа харуулж байгаа юм.

Тухайлбал, Шри Ланкийн "Номын хүрдэн" төв, Энэтхэгийн "Дэлхийн буддын судлалын" төв" Америкийн Нью-Жерсийн их сургуулийн "Буддын судлалын" газар, Английн "Орчин үеийн буддизмын судалгааны" төв, Санкт-Петербургийн их сургуулийн "Буддын соёл судлалын" тасаг зэрэг олон судалгааны хүрээлэнгүүдэд "Буддын шашин-гүн ухааны" судалгаа өрнүүлэн, орчин үеийн сэтгэлгээний үүднээс үнэлэмжлэн боловсруулж, судалгааны цаашдын хандлагыг тодорхойлох болов. Эдгээр судалгааны үндсэн чиглэл нь буддын шашин, түүний философийн үндэслэл хийгээд буддын соёл, нийгмийн генотип буюу соёл гэсэн нийгмийн оюуны хөгжлийн 2 хүчин зүйлийн харилцан холбоонд судалж буйгаар онцлог талтай байгаа юм. Уул асуудалд хүндлэлтэй хандаж нийгэмд эзлэх байр суурь, түүний эерэг сөрөг талыг үнэлэмжлэн илэрхийлж байгаад уул судалгааны ач холбогдол оршиж байгаа юм.

Манай орны хувьд буддизмыг онолын сэтгэлгээний үүднээс судлах хандлага гүнзгийрч буй төлөв ажиглагддаг. Үүнд МУИС-ийн "Буддын соёл судлалын" төв, "Монголын буддын соёлын" хүрээлэн, "Монголын йог парапсихологийн" нийгэмлэгүүд буддын судалгаа хийж эх зохиолын цуврал нийтлэх, эх зохиол сурвалжид шинжилгээ хийх, маргаан зохиох, бүтээл шалгаруулах, тарнийн гүнзгий логик утгаар трансформаци хийх зэргээр орчин үеийн сэтгэлгээний үүднээс шинжлэн судалж буй нь судалгааны үнэмжлэхүйн утгыг гүнзгийрүүлэхэд ач холбогдлоо өгч байна хэмээн үзэж болно.

Гуравдугаарт, Буддизм, түүний үзэл санааг дэлгэрүүлэх, сурталчлах замаар олон нийтийн оюуны ухамсарт хүргэх нь үнэлэмжийн зүй ёсны хэмжүүр хэмээн үзэхэд хүргэж байна. Ийм хэмжүүрийн гол хандлага нь шашин орших, эс оршихуйн тухай асуудлыг нотлох буюу няцаахад бус, харин шашны асуудлыг рациональ түвшинд ухаарах, номын үнэн чанарыг дэлгэрүүлэх явдал мөн. Учир нь өнөөгийн ертөнцөд шашны соёлын үүрэг (роль) нөлөө улам гүнзгийрч буйтай энэ нь холбоотой гэж үзэж болно.

Орчин үеийн хандлагаас үзэхэд буддын шашны олон байгууллага буй болж буддын номлох эрдмийн санг сурталчлан дэлгэрүүлж, үүгээрээ нийт

төрөлхтний оюуны ухамсарт гүн нөлөө үзүүлж буй нь буддизмын орчин үеийн үнэмжийн нотолгооны илэрхийлэл хэмээн үзэж болох юм. Эдгээрт, тухайлбал "Дэлхийн буддистуудын холбоо", "Буддизм ба шашин хоорондын дэлхий дахины холбоо", Японы их хөлгөний "Номын ертөнц", мөн "Их хөлгөний уламжлал хадгалах төв", английн "Буддистуудын нийгэмлэг", "Азийн буддистуудын энхтайвны бага хурал" зэрэг төрийн бус байгууллагууд үүнд хамаарч байна. Сурталчилгааны чиглэл нь:

1. Буддын хүмүүнлэг сургаалыг орчин үеийн энхтайван, хамтын ажиллагааны угшилтай холбон асуудал дэвшүүлэх,
2. Ерийн шүтлэгтэн, эс шүтлэгтний дунд шашны гэгээрэхүй, ариусахуй үйлийг хүмүүжил төлөвшилтэй холбон соён гэгээрүүлэх үүргийг гүйцэтгэх,
3. Ертөнцийг "амьд хүрээ" гэдэг дорнын төсөөллийг хүн зонд хүргэх, тэр чанараараа хүмүүжил төлөвшлийн хүчин зүйл болгож, хүний дотоод ертөнцөд чиглэгдсэн үйл ажиллагааны нэгэн хувилбар болгон дэвшүүлэхэд зориулагдаж байгаад түүний онцлог оршино

Эцэст нь дөрөвдүгээрт, Буддын гүн ухааны орчин үеийн үнэлэмжид зүй ёсоор хөндөгдөх зүйл бол түүний баялаг агуулгыг эрдмийн их ухаанаар баяжуулан, эрдэм шинжилгээний үүднээс нотлон буулгах явдал болно.

Бурхны шашин төвт дорнын соёл иргэншил үүссэнээр нийгмийн шинэ үнэлэмж бүрэлдэн тогтсон төдийгүй, ертөнцийг үзэх шинэ ойлголт төрүүлэхэд хүргэсэн юм. Энэ нь зөвхөн шүтлэг бишрэлийн мэдрэмжээр хязгаарлагдахад бус, мэдлэг олгох сэтгэлгээний баялаг хуримтлалыг бий болгосноороо итгэл үнэмшлийг олж, тэр чанараараа оршихуйн шимт хөрс болж хөгжин гүнзгийрэхэд хүргэв гэсэн хэрэг болой.

Энэ бол буддын шашин, нийгмийн амьдралд гүйцэтгэсэн үүргээрээ өргөн хүрээтэй ойлголтыг, тухайлбал гүн ухаан, соёл, шинжлэх ухааны салбарыг хамаарч, тэр чанараараа нийгмийн сэтгэлгээнд, тэр ч байтугай орчин үеийн байгалийн шинжлэлийн суут нээлттэй дүйцэхүйц эрдэм ухааны ололтыг өөртөө тусган илэрхийлсэн байдгийг эрдэмтэд тэмдэглэсэн нь буй. Тухайлбал, масс, энергийн тэнцүү чанарыг тогтоосон Эйнштейны тэгшитгэл, огторгуй хугацаа 2 салангид бус, нэгэн шүтэлцээнд орших хурьцангуйн тусгай ба ерөнхийн онол буддын нууц тарнийн гүн нарийн дээд бясалгалын үрээр хөндөгдсөн нөхөн барилдахуйн ойлголттой холбоотой байсан нь түүнийг

үнэлэмжлэх нэгэн тод шалгуур болох төдийгүй, үнэлэх ёстой зүйлийн маань үнэт чанар мөн болно.

Ийнхүү буддын гүн ухааны орчин үеийн үнэлэмжийн асуудал нийгэм түүхийн үйл явцаар хөндөгдөн илэрхийлэгдэж, түүнийг судалсан эрдэмтэн мэргэдийн бүтээлээр тодотгогдон, оюуны амьдралын судалгааны нэгэн чиг хандлагыг тодорхойлох болов. Энэ бол шашин судлалын асуудалд буддын шашин-гүн ухааны ойлголт судлагааны зайлшгүй объект болж, түүнийг үнэлэмжлэх асуудал тод илэрч буйн баримтлал мөн хэмээн үзэхэд хүргэж байна.

Annotation

An Evaluative Approach of the Buddhist Philosophy

There is an increasing significance among the religious studies on the role of Buddhism and influence on the development of social processes. As a result, there is a certain attempt to use evaluative approaches to assess Buddhism's role on the development of those social processes.

In this regard, the author attempts to outline the evaluative approaches of the Buddhist philosophy as follows:

1. Buddhist innovations and their evaluations
2. Buddhist studies and their evaluations
3. Buddhist religious advertisements and their evaluations
4. Role of Buddhism in the social life and its evaluation

Ном зүй

1. Интернет. Буддизм. Tibet office-Цахим хуудас. 2005
2. Symposium on Artificial Intelligence in Medicine (Cambridge). 1979
3. The Light of the Dharma. 1963, Jan, vol IX №4, p 42
4. Кондрад Н. И. "Средние века" в исторической науке-запад и восток, 1966, с.103
5. Дээрхийн гэгээн Далай лам. ШУТИС-ийн хэвлэл, 2002 он